


Аймгийн Засаг даргын 2017 оны 9 дүгээр
сарын 22-ны өдрийн 166 тоот
захирамжийн хавсралт



Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа бүтээлч багш нарыг урамшуулах журам

Нэг. Зорилго

1.1. Сургуулийн өмнөх боловсрол болон бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, мэргэжилтэй ажилтан сургаж бэлтгэх чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүтээлч санаачилгатай ажиллаж байгаа тэргүүний багш нарын арга туршлагыг аймаг, улсын хэмжээнд сурталчлан таниулах, шилдэг арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, урамшуулах, дэмжих, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулахад оршино.

Хоёр. Нийтлэг үндэслэл

- 2.1. Энэхүү журам нь аймгийн ЕБС, цэцэрлэгийн багш, МСҮТ-ийн багш нарт хамаарна.
- 2.2. Жил бүр 21 хүртэл "Шилдэг багш" –ийг шалгаруулан урамшуулах ба тухайн багш нар нь орон нутагтаа сүүлийн 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байна.
- 2.3. Монголын багш нарын баяраар аймгийн "Шилдэг багш"-аар шалгарсан багш нарын шагналыг гардуулна.

Гурав. Аймгийн "Шилдэг багш"- д тавигдах шалгуур

- 3.1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлагдсан "Улс, аймаг, нийслэлийн оны тэргүүний багш" шалгаруулах болзлын үзүүлэлтийг 80-аас доошгүй хувиар биелүүлсэн байх
- 3.2. Тухайн онд багшлах арга зүй болон боловсруулсан мэргэжлийн бүтээлээ 2-оос доошгүй сургууль, цэцэрлэгт түгээн дэлгэрүүлсэн болон бусад багш нар авч хэрэгжүүлсэн байх, МСҮТ-ийн мэргэжлийн багш нь тухайн хичээлийн жилд чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулан сургалтад ашигласан байх ба сайн үр дүнг түгээн дэлгэрүүлсэн байх
- 3.3. Мэргэжлийн болон анги удирдсан багшийн суралцагчдад сурах арга барил, харилцаа, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, эрүүл чийрэг бие бялдартай, өөртөө итгэлтэй, зөв хандлага төлөвшилтэй, мэргэжлийн үр чадвар сайтай иргэн болгон төлөвшүүлэх үйл ажиллагаа нь хүүхэд, эцэг эх, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байх
- 3.4. Хамтран ажиллах арга туршлагыг хуримтлуулж, бусад багш нарын хөгжилд хувь нэмрээ оруулсан байх, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш нарын хувьд мэргэжлийн ангийн сурагчдын үйлдвэрлэлийн дадлага, үйлдвэр сургалтын хичээлийг зохион байгуулахдаа, тэдний мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, сургуулийн тохижилт үйлчилгээ болон хамт олон багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжин тусалсан, бүтээлч ажлуудыг санаачлан хийсэн байх
- 3.5. Боловсролын агуулгын стандартын хэрэгжилт нь ерөнхий боловсролын сургуульд хөндлөнгийн үнэлгээгээр 60-аас доошгүй, цэцэрлэгт 90-ээс доошгүй хувьтай, МСҮТ-ийн багшийн хувьд суралцагчдын мэргэжлийн үр чадварын хөндлөнгийн үнэлгээ 70 хувиас доошгүй байх

3.6. Багшийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллаж, сурагч, эцэг эх, хамт олны сэтгэл ханамж 90-ээс доошгүй хувьтай байх

3.7. Багш өөрөө болон шавь нар нь аймаг, бүс, улсын чанартай мэргэжлийн олимпиад, ажил мэргэжлийн уралдаан тэмцээнд тухайн хичээлийн жилд тодорхой амжилт гаргасан байх

3.8. Төрийн болон иргэний нийгэм, олон улсын байгууллага, иргэд олон нийттэй хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байх

Дөрөв. Үнэлгээ дүгнэлт, шалгаруулалт

4.1. Тухайн байгууллагын нийт багшийн 10-аас хэтрэхгүй хувьтай тэнцэх тооны журмын шаардлага хангасан багш нарын тодорхойлолтыг энэхүү журмын 3.1-3.7-д заасан шалгуур бүрийн биелэлтийг баталгаажуулсан материалыг сургууль, цэцэрлэг, МСҮТ-ийн хамт олны хурлаар хэлэлцэж дэмжигдсэн байх ба хамт жил бүрийн 6 дугаар сарын 15-ны дотор аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт ирүүлнэ. МСҮТ-өөс 2 жилд нэг удаа ерөнхий эрдмийн 1 багш, мэргэжлийн 2 багшийн тодорхойлолтыг дээрх журамд заасны дагуу тухайн хугацаанд ирүүлнэ.

4.2. Энэхүү шалгуурыг үнэлэх аргачлалыг Боловсрол, соёл, урлагийн газар боловсруулж батална.

4.3. Журмын шалгуур үзүүлэлтийн дагуу багш нарыг дүгнэсэн үнэлгээний босго 80 онооноос дээш байна.

4.4. Боловсрол соёл урлагийн газрын "Арга зүйн зөвлөл" багш нарын тодорхойлолт материалыг хүлээн авч аргачлалын дагуу шалгаруулан онооны дарааллаар эрэмбэлэн 9 дүгээр сарын 25-ны дотор багтаан Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлнэ.

4.5. "Шилдэг багш"-аар 8 удаа шалгарсан тохиолдолд орон сууцны дэмжлэг үзүүлнэ.

Тав. Шагналыг урамшуулал олгох

5.1. Аймгийн Засаг даргын захирамжаар шилдэг багшийн эгнээнд шалгарсан багш тус бүрт 1000000 /нэг сая/ төгрөгийн мөнгөн шагналыг олгоно.

5.2. Аймгийн "Шилдэг багш" – д тэргүүн байр эзэлсэн багшийг "Улсын тэргүүний багш" - ийн шалгаруулалтад оролцуулна.

Зургаа. Арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, эзэмшүүлэх

6.1. Шилдэг багшийн арга туршлага, бүтээлийг сурталчлан, харилцан туршлага солилцуулна.

6.2. Шилдэг багшийн боловсруулсан бүтээл, арга туршлагыг цахим хэлбэрээр сурталчлан нийтийн хүртээл болгоно.

6.3. Шилдэг багш нараас баг бүрдүүлж, аймгийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах, багш нарын заах арга, үр чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

Долоо. Санхүүжилт

7.1. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэнэ.